

“Монголын нууц товчоон”-ы “ne’üle” хэмээх
үгийн утгыг тодруулах нь

Эрдэнэбилэгийн ЭРДЭНЭЗУУ¹

Монгол Улс, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Харьцуулсан хэл шинжлэлийн салбар

Submitted: September 25, 2025 | **Accepted:** November 11, 2025

Хураангуй: Энэхүү өгүүлэлд “Монголын нууц товчоон”-ы §245, §254-р зүйлд Бөртэ болон Есүй хатны үгэнд тохиолдож буй “ne’üle” хэмээх үгийг МНТ судлаачид хэрхэн тайлсан хийгээд хожмын монгол сурвалж бичгүүдэд буй эсэх талаар магадалж, уг үгийн гарлыг алтайн хэлнүүдийн баримтад түшин тодруулахыг зорилоо.

Түлхүүр үг: Монголын Нууц Товчоон, монголын түүхэн сурвалж бичгүүд, алтайн хэлнүүд, үгийн гарал, үгийн утга

**Clarifying the Meaning of the Word ‘ne’üle’
in The Secret History of the Mongols**

ERDENEZUU Erdenebileg

*Department of Comparative Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia*

Abstract: This article aims to examine the interpretation of the word *ne’üle*, as it appears in the speeches of Börte and Yesui in §245 and §254 of *The Secret History of the Mongols (SHM)*, to assess its occurrences in later Mongolian sources, and to elucidate its etymology with reference to evidence from the Altaic language family.

Keywords: *The Secret History of the Mongols, Mongolian historical sources, Altaic languages, etymology, word meaning*

¹© Э.Эрдэнэзуу, 2025

Email: erdenezuu@mas.ac.mn,

1. Удиртгал

Монголын нууц товчооны §245, §254 зүйлд ‘*ne’üle*’ хэмээх үг хоёр удаа тохиолдоно. Үүнээс, эхний удаад есөн хэлтэн улс Хонхотаны Мэнлиг эцгийн хүү Тэв Тэнгэрт чуулж, Тэв Тэнгэрийн хүч, нэр сүр ихээхэн мандсан хийгээд Чингис хааны бага дүү Тэмүгэ отчигины харьяанд байсан албат иргэд Тэв Тэнгэрт дүрвэж, Тэмүгэ отчигин албат иргэнээ авъя хэмээн Сохор нэрт элчээ илгээвээс Сохор нэрт элчийг нь занчиж, эмээлийг нь үүрүүлэн явган хариулав. Отчигин ноёныг өөрийн биеэр очиход Тэв Тэнгэр өмнөө мөн наманчлан сөгдүүлэв. Эл бүгдийн учир Тэмүгэ отчигин Чингис хаанд зорин мэдүүлсэнд, Бөртэ үжин §245: **ne’üle** metü beye cinu negüs odu’asu netkel metü ulus cinu ken-e mede’ülkün tede tulu metü beye cinu tulbas odu’asu tuyal metü ulus cinu ken-e mede’ülkün tede (Rachewiltz, 1972: 141) *Нүүл мэт бие чинь нэхэс одвоос нэтгэл мэт улс чинь хэнээ мэдүүлэхүүн тэд, тул мэт бие чинь тулбас одвоос туял мэт улс чинь хэнээ мэдүүлэхүүн тэд (Хөр. Э.Э)* хэмээн Тэмүгэ отчигиныг өмөөрч, Чингис хааныг халиваас тэд долоон Хонхотан, Тэв Тэнгэр хэнд улс орныг мэдүүлэх хэмээн сэрэмжлүүлэн хэлсэн үгнээ тохиолдоно.

Удаах нь Сартуул иргэнд Ухуна тэргүүтэн зуун элчээ хядуулсанд Чингис хаан ихэд хилэгнэн, Сартуул иргэнийг дайлаар мордох үед Есүй хатан их хааныг дайны хөлд эрсдэн, зовон зүдэн хураасан улс нь эрх мэдлийн төлөө өөр зуур тэмцэлдэж таран бутруузай хэмээн сэрэмжлүүлж төрсөн дөрвөн хөвүүнээсээ нэгийг хаан ор залгамжлуулахаар мэдүүлэхийг ятган сануулсан §254: **ne’üle** metü beye cinu negüs odu’asu netkel metü ulus-iyān ken-e gēmü tulu metü beye cinu tulbas odu’asu tuyal metü ulus-iyān ken-e gēmü (Rachewiltz, 1972: 149) *Нүүл мэт бие чинь нэхэс одвоос нэтгэл мэт улсаа хэнээ гэмү, тул мэт бие чинь тулбас одвоос туял мэт улсаа хэнээ гэмү. (Хөр. Э.Э)* үгэнд тус тус тохиолдоно.

Энэхүү ‘*ne’üle*’ хэмээх үгийг МНТ-д (提元列) хэмээн тэмдэглэж, хажуугийн хадмал орчуулгад 古樹 (10:36:09, §245), 大木 (11:21:01, §254) (Kuribayashi, 2009: 315) “хөгшин мод, том мод” гэж орчуулжээ. Гэхдээ зарим судлаач МНТ-ы хажуугийн хадмал орчуулгад бүрэн дүүрэн итгэж үл болох тухай жишээ баримт олонтоо дурдсан (Сёсенбаятур, 2005: 65-69; Сайинцоьту, 2003: 28-29) бөгөөд бид ч мөн үүнтэй санал нэгдэж, дээрх орчуулгаас өөрөөр үзсэн болно. Уг үзлээ МНТ-ы ‘*ne’üle*’ хэмээх үгийг МНТ судлаач эрдэмтэд хэрхэн тайлж уншсан, МНТ-оос хойших монгол сурвалж бичгүүдэд тохиолдох эсэх талаар магадалж, уг үгийн гарлыг алтайн хэлнүүдийн үгийн эхний “н” сугарах, сэлгэх үзэгдлээр тодруулахыг зорилоо.

2. Судалгааны арга

Тус судалгаа нь хам болон цуваа (synchrony and diachrony) цагийн судалгаанд хамаарах бөгөөд хэл шинжлэлийн задлан шинжлэх болон нэгтгэн дүгнэх аргыг хэрэглэв.

Юуны өмнө ‘ne’üle’ хэмээх үгийг МНТ судлаач голлох эрдэмтэд хэрхэн тайлж уншсан, өөрсдийн орчуулгад хэрхэн тусгасан талаар дурдъя.

3.1. Монгол Улсын МНТ судлаач эрдэмтэд хэрхэн тайлсан

Монголын нууц товчооныг анх удаа монгол хэлнээ орчуулсан хүн бол Баргын бодлогот гүн Цэнд юм. Тэр бээр “Юань улсын нууц түүх” (Cengde, 1917) номдоо **niyuli** metü bey-e čin-e niγus odusu nidqal metü ulus čin-e kenyi medegdekün tede (**нигүли** мэт бие чинь нигус одсу нидхал мэт улс чинь хэнийг мэдэгдэхүүн гэд Э.Э) (Cengdü, 2017: 519); **niryuyu** metü bey-e čini niγus odusu. nidqal metü ulus čini ken ni gemüi. törü metü bey-e čini tülbas odusu tuyal metü ulus-i činu ken ni gemüi (Cengdü, 2017: 519) (**нүрүү** мэт бие чинь нигус одсу, нидхал мэт улс чинь хэн нь гэмүй, төр мэт бие чинь тулбас одсу туял мэт улсыг чинь хэн нь гэмүй (Хөр. Э.Э.) хэмээн орчуулжээ. Эхний орчуулгад “niyuli” гэж орчуулсан бөгөөд энэ үг нь чухам юу болох талаар тайлбарласангүй, хажуугийн орчуулгад ч хадсангүй. Харин хоёр дахь удаад “niryuyu” гэж орчуулжээ. Мөн хажуугийн орчуулгад энэ үгийн тайлбарыг хадсангүй.

Ц.Дамдинсүрэн МНТ-ы орчуулгууддаа (Дамдинсүрэн, 1947; 1975; 1976; 1985; 1990) ... **egüle** metü bey-e čini ügei bolju odbasu (Damdinsürüng, 1947: 236), **ayula** metü bey-e čini nuraju odbasu (Damdinsürüng, 1947: 249); **Уул** мэт биеийг чинь үгүй болж одвол ... (Дамдинсүрэн, 1990: 225); ... **Уул** мэт бие чинь нурж одвол улс олон Монголы чинь хэн захирах юм бэ? (Дамдинсүрэн, 1990: 225) хэмээн ‘үүл’, ‘уул’ гэх үгсээр утгачилан буулгажээ. **Уул** мэт бие... улс олон Монгол хэмээсэн нь уран сайхны аргаар толгой холбосон холболт болно.

Ш.Гаадамба МНТ-ыг худам монгол бичгээр сэргээсэн сийрүүлэг эхдээ **negüle** metü bey-e činu neküs odbasu nedkel metü ulus činu ken-e medelekün tede (Гаадамба, 1990: 173) хэмээн МНТ-ы уг эхийг барьж буулгаж, эл үгийг бусад МНТ судлагч эрдэмтэд хэрхэн орчуулсан, чухам яагаад “үүл” хэмээн орчуулах нь зөв болох талаар өөрийн саналыг дэвшүүлсэн юм. Түүний дэвшүүлсэн санал нь: “... Бидний бодвол нэгүлэ (эгүлэ – үүл) гэсэн эртний монгол үгийг XIV зууны үед галиглагч нар өөрсдийн үеийн монгол хэлний дуудлага аялгаар “нүүлэ” гэж ташаа галигласны улмаас хожим хийсэн хадмал болон бусад орчуулга хөгшин дархи мод, модны гол, тайрдас гэх мэт өөр утгатай модтой хутгаж буруу орчуулсан бололтой. Учир нь “нүүлэ” гэдэг модны үндсэнд гарсан түймрийг хэлдэг бөгөөд түймэрт шатсан том том дархи модны иш голыг ч бас “нүүлэ” гэж хэлэлцдэг байна. Энэ үг худам монгол бичгээр нүүлэ бус хар “нэгүлэ” буюу “эгүлэ” гэж бичээстэй байж гэж таамагламаар байна. Юу гэвэл, Лувсанданзан энэ үгийг “эгүлэн” (31, II, 42) гэж бичсэнээс гадна Козины сийрүүлэг эхийн дотор (14: 389) “нэгүлэн” гэж бичсэнийг Мостарт иш татсан байна. Түүнээс гадна “нэкүс (нэгүн) одбасу” гэсэн үг бол эргээж хөрвөх, зөөлөн зүйлд холбогдох тодотгол үг юм. Жишээ нь: Жэлмэ-г Чингис хаанд Жарчигудай өвгөн “эгүдэ бэн нэкүл (үүдээ сөхүүл, эргүүлүүл)” гэж өгдөг. Гэрийн эсгий үүдийг “нэкүс” эргүүлээд гэр дээр хаяж болно. Харин хөгшин

дархи бүдүүн мод ямар ч тохиолдолд “нэхүс нахис” хийж унах учиргүй биз ээ. Үүл гэдэг уг монгол хэлэнд “нэгүкү” (нүүх) гэсэн үгнээс үүсч нэгүлэн – нэгүлэ – эгүлэн – эгүлэ – эүл – үүл” гэж хувиран хувирсаар үүссэн нь илэрхий” (Гаадамба, 1990: 394) хэмээн тайлбарлажээ. Бид ч үүнтэй санал нэг агаад уг үндэслэлийг улам тодруулж, шинэлэг жишээ баримтаар дэлгэрүүлэн энэхүү өгүүллийг бичсэн болно.

Б.Сумъяабаатар МНТ-ы үсгийн галиг, иж судалгаа (Сумъяабаатар, 1990, 2020)-даа хятад ханзны дуудлагыг барин **negüle** metü bey-e ċinu **нэгүл** мэт бие-чинү (Сумъяабаатар, 2020: 1151, 1194) гэж буулгасан ч чухам ямар утгатай үг болохыг тайлбарласангүй.

Д.Цэрэнсодном МНТ-ы орчуулгадаа **negüle** metü bey-e ċini neküs (kijü) odbasu (Āeringsodnam, 1993: 226), **neüle** metü bey-e ċini meküs (kijü) odbasu (Āeringsodnam, 1993: 236) хэмээн буулгаж, үгийн тайлбар хэсэгт “унанги бүдүүн мод” гэж тайлбарласан өмнөх эрдэмтдийн саналыг дагажээ.

Ш.Чоймаа МНТ-ы орчуулгууддаа (Чоймаа, 2002, 2006, 2011, 2015, 2019, 2022) ... **нэгүл** мэт бие чинү нэхэс одвоос, нитгэл мэт улсыг чину хэнээ (хэнд) мэдүүлэхүн, тэд! Тул мэт бие чинь тулбас одвоос туял мэт улсыг чинь хэнд мэдүүлэхүүн, тэд (Чоймаа, 2011: 205) гэж буулгаж, **нэгүл мэт** - аварга том мод мэт (Чоймаа, 2011: 205) гэсэн утгын тайлбар хийжээ.

Г.Гантогтох, С.Мөнхсайхан нар МНТ-ы орчуулгадаа: “.. **нүүлэ** мэтэ бэешини (Гантогтох, 2018: 199), ... **нэгүл** мэт бие чину (Мөнхсайхан, 2024: 215, 218) хэмээн буулгаж, үгийн тайлбар хэсэгт аварга дархи (том) мод гэсэн өмнөх эрдэмтдийн саналыг дэмжиж, тус утгаар тайлбарлав.

Монгол Улсын монгол хэл, түүхийн ухааны МНТ судлаач эрдэмтдийн хамтын бүтээл “Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоон”-д мөн “**нэгүл мэт**” хэмээн буулгаж, аварга том мод мэт (ДТМНТ, 2024: 557) гэсэн утгын тайлбар хаджээ.

Монгол Улс дахь МНТ судлаач голлох эрдэмтэд хэрхэн тайлбарласныг нэгтгэвэл:

Судлаач эрдэмтэн	Хэрхэн буулгасан	Утгын тайлбар
Цэнд гүн (1917)	niyuli niruyu	нигули нуруу
Ц.Дамдинсүрэн (1947, 1975, 1976, 1985, 1990)	egüle metü bey-e ċinu ayula metü bey-e ċinu үүл мэт биеийг чинь, үүл мэт бие чинь нурж одвол	үүл уул
Ш.Гаадамба (1990)	negüle (үүл) metü bey-e ċinu	үүл
Б.Сумъяабаатар (1990, 2020)	negüle metü bey-e ċinu нэгүл мэт бие-чинү	-
Д.Цэрэнсодном (1993, 2000)	negüle metü bey-e ċinu нэгүл мэт бие чинь	унанги бүдүүн мод,
Ш.Чоймаа (2002, 2006, 2011, 2015, 2019, 2022)	нэгүл мэт бие чинү	

Г.Гантогтох (2018)	<u>нүүлэ</u> мэтэ бээшни	аварга том мод
С.Мөнхсайхан (2014)	<u>нэгүл</u> мэт бие чину	
Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоо (2024)	<u>нэгүл</u> мэт	

3.2. Өвөр Монголын МНТ судлаач эрдэмтэд хэрхэн тайлсан

Хуасай Дугаржав ‘*negüle*’ (Quvasai Dugarjab, 1984: 218), Тайчууд Мансан ‘*šangši metü bey-e čini*’ (Tayičiyud Mansang, 1985, 2021), Ихмянгадай Иринчин МНТ-ы монгол бичгийн сэргээлтдээ ‘*negüle*’ (Irinčin Yekemingyadai, 1987: 233), Баяр МНТ-ы сэргээлт, эрдэм шинжилгээний галигтаа ‘*negüle*’ (Bayar, 1980, 2012, 2022: 1253), Элдэндэй, Ардажав нар “Монголын нууц товчооны сийрүүлэл тайлбар”-таа negüle metü bey-e činu neküs odbasu nedkel metü ulus činu ken-e medegülkün tere) хэмээн буулгаж *negüle* хэмээх үгийг *negüle* > *ne’üle* нүүл хэмээх нь модон нүүл. *Хассан бүдүүн модыг нүүл хэмээмүй* (*Хорин наймт тайлбар*), *боть XIV, нүүр 44*). *ne’üle* ~ *нүүлэ хэмээх нь I. Дарги* (*Унанги том мод*). 2. *Том модны тайрдас* (“*Буриад орос*” нүүр 350.В) (Eldendei, Ardajab, 1986: 797-798) хэмээн МНТ-ы хажуугийн орчуулгыг барин “мод” гэх утгаар тайлбарлажээ. Өвөр Монголын МНТ судлаач эрдэмтэд МНТ-ы хажуугийн хятад орчуулгыг даган ‘*negüle*’ хэмээх үгийг “бүдүүн мод” гэсэн утгаар тайлж, тайлбарлажээ.

3.3. МНТ судлаач бусад эрдэмтэд хэрхэн тайлж уншсан

С.А.Козин “Сокровенное сказание” номын орос хэлээрх орчуулгадаа “*Падет как увядшее древо Тело твое, государь.*” (Козин, 1941: 177) “*Хаантан минь! Таны бие хатаж өмхөрсөн мод мэт унах болно.*” (орч. Э.Э).

Erich Haenisch МНТ-ыг герман хэлээр орчуулсан “*De Geheime Geschichte der Mongolen*” номдоо “*Wahrlich, wenn dann später dein dem hohen Baumstamm gleicher Körper sich zum Fallen neigt* (Haenisch, 1941: 122) *Үнэхээр нэгэн өдөр таны бие өндөр мод мэт сөхрөн унаваас* (орч. Э.Э) гэжээ.

Шигэо Озава МНТ-ы эрдэм шинжилгээний галиг, япон хэлээрх орчуулгадаа ‘*ne’üle*’ хэмээн буулгаж, *老大 хөгшин мод* (Ozawa, 1989: 171) хэмээн орчуулж, өмнөх эрдэмтдийн ‘*унанги бүдүүн мод*’ гэсэн санал (Ozawa, 1989: 186)-ыг дэмжжээ.

Igor de Rachewiltz түүх ба хэлний тайлбар бүхий МНТ-ы англи орчуулгадаа “... *Like a great old tree: the notions of both ‘great’ and ‘old’ are inherent in the word ne’üle (= Mo. negüle[n]), which is why I translated it this way*” (Rachewiltz, 2004: 881) хэмээн ‘*ne’üle*’ хэмээх үгэнд *их ба хуучин* хэмээх утга аль аль нь агуулагдах учир ийн орчуулсан хэмээн тэмдэглэжээ.

Ононы Өргөнгө МНТ-ы англи орчуулгадаа “... *When your body, like an old and withered tree, comes falling down*” (Urgungge, 2005: 229) *Мөнөө хойно, бие тань өвгөрч хатсан мод мэт өнхөрч унаваас* (орч. Э.Э) гэжээ.

МНТ судлаач дээрх эрдэмтэд бүгд МНТ-ы хажуугийн орчуулгыг дагаж ‘*ne’üle*’ хэмээх үгийг ‘*хөгшин аварга мод*’ гэсэн утгаар орчуулсан байна.

3.4. Лувсанданзаны “Алтан товч”-д хэрхэн буулгасан

МНТ-ы утга бүрхэг, эргэлзээтэй үгсийг тодлоход юун түрүүнд XVII зууны Монголын түүхэн сурвалж бичгийн нэг Лувсанданзаны “Алтан товч”-той харгуулган тулгах хэрэгтэй. Лу. Алтан товчоос шүүн үзвэл: *mön-e qoyina egülen metü bey-e čin-u negün odbasu: itegel metü ulus-i čin-u ken-e medegülkün tede: tuli metü ulus-i činu tulbas odbasu: tün metü ulus-i činu ken-e medegülkün tede (Altan tobči, 1990: 97)... Мөнөө хойно үүлэн мэт биеийг чинь нүүн одвоос умгэл мэт улсыг чинь хэнээ мэдүүлэхүүн тэд. Туль мэт улсыг чинь тулбас одвоос тун мэт улсыг чинь хэнээ мэдүүлэхүүн тэд...* (хөр. Э.Э.) хэмээн “үүл” гэх үгээр буулгажээ. Лувсанданзан “Алтан товч”-оо бичихдээ МНТ-ы монгол бичгээрх уг эхийг барьсныг МНТ судлаач эрдэмтэд нэгэнтээ баталсан билээ (Чоймаа, 2002). Лувсанданзаны гарт байсан МНТ-ы уг эхэд ~~үүлэн~~ гэсэн хэлбэртэй бичигдсэнийг Лувсанданзан бээр egülen хэмээн уншсан нь илэрхий. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалд үгийн эхэнд орсон ‘а’, ‘е’ эгшгийг хоёр шүдээр, мөн ‘п’ гийгүүлэгчийн өмнөх цэгийг үл тавин бичдэг байсныг дундад үеийн монгол хэлний бичгийн дурсгалуудаас бид бэлээхэн харж болно. Тиймээс, гүүш Лувсанданзаны egülen хэмээн буулгасныг алдаа хэмээн үзэж болохгүй юм.

3.5. Бусад монгол сурвалж бичигт тохиолдож буй эсэх

Сурвалж бичиг	Тохиолдож буй хэлбэр
1. Цагаан түүх (XIII)	-
2. Юань улсын түүх (XIV)	-
3. “Хураангуй алтан товч” (XVII эхэн)	-
4. Лувсанданзан “Алтан товч” (XVII)	egülen (1990: 97)
5. Саган Сэцэн “Эрдэнийн товч” (1662)	-
6. Жамба “Асрагч нэртийн түүх” (1677)	-
7. “Шар тууж” (XVII сүүл)	-
8. Гомбожав “Тангын урсгал” (1725)	-
9. Ломи “Монгол боржигид овгийн түүх” (1732)	-
10. Мэргэн гэгээн “Алтан товч” (1765)	-
11. Рашпунцаг “Болор эрх” (1775)	-

МНТ-оос хойших монгол сурвалж бичгүүдээс эл хэсгийг эрвэл гагц Лувсанданзаны “Алтан товч”-д тохиолдох ба бусад сурвалжид тохиолдохгүй байна. Харин Чингис хаан тэнгэрт халихынхаа өмнө

... Үнэн үгэндээ хүрсэн хүний сэтгэл бэх

Өчүүхэн дураа барьж олон лугаа зохь

Үнэхээр нүүн нөгчих бие биш үү

Хойт сайнаа эрэгтүн

Хубилай хүүхний (=хүүгийн) үг өөр буй

Түүний үгээр явагтун (EMQÜYSTO: 45).

хэмээн хүмүүний биеийг “*Үнэхээр нүүн нөгчих бие биш үү*” хэмээн захин сургасан сургаалын хэсэг Хураангуй Алтан товч (QÜQAT : 99), Лу. Алтан товч (LAT: 234), Саган Сэцэний Эрдэнийн товч (QÜET: 134), Асрагч нэртийн түүх (ANT: 41), Шар тууж (EMQÜYSTO: 45) зэрэг олон сурвалжид тохиолдох бөгөөд төрсөн энэ биеийг төд удалгүй нүүн арилах ‘үүл’-ний шилжих хөдөлгөөнтэй адилтган зүйрлэсэн энэхүү зүйрлэл нь нүүдэлчдийн сэтгэхүйд хүмүүний бие бол үнэн магадгүй, бат суурьгүй, үүл адил нэгэн цагт нүүн одох оргүй хоосон зүйл юм гэсэн эртний сэтгэлгээний тусгал юм.

3.6. Хэсэг байшингийн чулууны бичээс дэх баримт

Монгол Улсын Дорноговь аймгийн Их хэт сумын нутаг Бүсийн чулуу хэмээх газраас олдсон XVI зууны сүүл үед хамаарах “Хэсэг байшингийн чулууны бичээс” (Пэрлээ, 1961: 60-65; Гансүх, 2019: 53-69; Нацагдорж, 2020: 110-147)-т МНТ-ы өгүүлэн буй хэсэгтэй тохирох мөр тохиолдож буй нь сонирхолтой агаад МНТ-ы §245, §254 зүйлд гарч буй энэхүү тогтсон хэллэгийг ямартай ч XVII зуун хүртэл идэвхтэй хэрэглэж байжээ гэж үзэж болохоор баримт юм. Тус бичээст

ayula metü nereten oylus jiram

olan ulus irgen qoçuraquy-a aci ügei aji:

[tulu met]-ü nereten tulbas eçim

tunıysan ulus irgen qoçuruquy-a aci ügei aji: (Нацагдорж, 2020: 120)

Уул мэт нэртэн оглос жирам (одном)

Олон улс иргэн хоцрохуйяа ач үгүй аж

[Тул мэт] нэртэн тулбас эчим

Тунасан улс иргэн хоцрохуйяа ач үгүй аж.

Хөшөөний бичээст ‘уул’-аар олонд хүндтэй, нөмөр нөөлөг болсон хаад ихсийг төлөөлүүлэн, тэрхүү уул мэт их хүний нөгчин одохыг ‘оглос’ хэмээх дүрс дуурайх үгээр тодотгожээ. Энэхүү дүрс дуурайх үг нь ‘огло-’ хэмээх үйл үндсэнд тухайн үйлийн огзом хөдлөхийг заах ‘-с’ дагавар залгаж үүссэн хэлбэр юм. ‘оглос’-ыг хад, чулуу мэтийн тэр бүрийд үл хөдлөх тогтонги зүйлийн гэнэтийн хөдөлгөөнийг илэрхийлэхэд хэрэглэж буйг мөн доорх жишээнээс харж болно.

1. *огло татах* - Юмны өнгөр хэсэгхэн газар ховх татах (МХДТТ: 66518)
2. *огло цохих* – Ховхорч унатал нь хүчтэй цохих (МХДТТ: 66518)
3. *огло үсрэх* - а. Ямар нэгэн зүйл үндсээрээ салах; оглорох б. Гэнэт давхийн харайх (МХДТТ: 66518)
4. *огло харайх* - Гэнэт үсрэн босох (МХДТТ: 66518) гэх мэт.

XIII зуунд их үүл мэт хүний гэнэт нүүж одох адил үгүй болохыг ‘нэхэс’ гэх үгээр, XVI зууны сүүл, XVII зууны эхэнд уул мэт хүний гэнэт одохыг “оглос” гэх дүрс дуурайх үгээр тус тус утгын нарийн ялгаатай тодотгон илэрхийлсэн нь санамсаргүй онолт биш бөгөөд хэл, сэтгэхүйн холбоо хамаарал, монгол

хэлний эгшиг авианы чанга хөндий, гийгүүлэгч авианы дуу, анирын шинжээс үүдсэн утгын ондоошил, монгол хэлний дотоод зүй тогтлын дагуу илрэн гарч буй хэлний нөхцөлт бус хэв шинжийн нэгэн жишээ юм.

4. МНТ дахь “үүл”-ний үнэлэмж

Өгүүлэн буй хоёр тохиолдлыг “үүл” хэмээн үзвэл, МНТ-д “үүл” гэх үг нийт 4 удаа тохиолдож байна. Бусад 2 тохиолдол нь:

МНТ-ы §230: cinggis-qahan ügüleriin **e'ületei** söni örügetei ger minu e'eren kebtejü (Rachewiltz, 1972: 133) *Чингис хаан өгүүллрүүн: Үүлтэй шөнө өрхтэй гэр мину ээрэн хэвтэж.* (хөр. Э.Э.);

МНТ-ы §238: ui'ud-un idu'ut cinggis-qahan-tur elcin ilējü'üi atkirag (?) darbai qoyar elcin-iyer öcijü ilērün **e'ülen** arilju eke naran üjeksen metü mölsün arilju müren usun oluqsan metü (Rachewiltz, 1972: 136) *Үйгудын Идүгүд Чингис хаанд элчин илгээжүхүй. Адхираг, Дарбай хоёр элчээр өчиж илгээрүүн: “Үүл арилж эх наран үзсэн мэт, мөлсүн (мөс) арилж мөрөн ус олсон мэт.* (хөр. Э.Э.)

МНТ-ы дээрх тохиолдлуудаас тухайн үеийн монгол хүний үүлийг үзэх үнэлэмжийг ажиглавал:

1. Үүл - хар бараан юм
2. Үүл - бөөгнөрсөн их юм

гэсэн үнэлэмж илэрч байна. Энэхүү үнэлэмж нь гагц монгол гэлтгүй бусад нүүдэлчин угсааны улсууд дунд ч мөн адил ажээ. XVII зууны эхэн үед зохиогдсон “Манжийн үнэн магад хууль”-д монголчуудыг “үүл”-тэй зүйрлэсэн жишээ бий. Сийрүүлбээс:

Ma. *tere inenggi abqa ayara-de. genggiyen han hendume. mongyo gurun-i banjirengge. ere ayara tugi adali qai. tugi isaçi aya ayambi. mongyo aiman açafi čooha ilimbi. mongyo aiman açaha čooha faҗcarangge. tugi faҗcafi aya җalandara adali qai.*

Mo. *tere ediir boruyan oroqui-dur. gegen qayan jarliy bolur-un[=bolurun]. mongyol ulus-un yabudal inu ene oroqu boruyan-u egülen metü. egülen cуylabasu boruyan oromi. mongyol qamuy-iyar neyilebesü çeriglemü. mongyol-un çerig tarqaqui inu. egülen tarqayad boruyan arilqui metü (Manju yargiyan qooli: 357) Тэр өдөр бороо орохуйд Гэгээн хаан зарлиг болруун: Монгол улсын явдал нь энэ орох борооны үүл мэт. Үүл цуглаваас бороо орму. Монгол хамгаар нийлбээс цэрэглэмүй. Монголын цэрэг тархах нь үүл тархаад, бороо арилах мэт (хөр. Э.Э.)*

Манж нарын “үүл”-ийг үзэх үзэл ч МНТ-ы үүлний үнэлэмжтэй төсөөтэй мэт. Ер нүүдэлчин угсааны улсуудын сэтгэхүйд “үүл” нь хөдлөнгө, хөвсгөнүүр гэх сөрөг үнэлэмжээс гадна аадар хур оруулах чадалтай “ер бусын хүчирхэг юм” гэх утгыг давхар илтгэж байна.

Эдгээр үнэлэмжээс үзвэл, МНТ-ы “нэгүлэ мэт бие” хэмээх нь унанги аварга том бүдүүн мод бус, хуран цугласан “их үүл”-ээр адилтгасан адилтгал мэт.

5. МНТ дахь шүлгийн эн зэрэгцүүлэх ёс

МНТ зохиолын шүлгийн агуулга, утга санааг үнэн зөв, бүрэн гүйцэд ухахад түүний шүлгийн тогтолцоог сайтар анхаарах хэрэгтэй юм. МНТ дахь шүлгийн тогтолцоо, тэр тусмаа шүлгийн эн зэрэгцүүлэх ёсны талаар профессор Ш.Чоймаа сонирхолтой ажиглалт хийсэн юм. Тэр бээр “Эн зэрэгцэн бүхий хоёр мөр, хоёр бадаг, хэд хэдэн бадгийн үг хэллэг нь адил төстэй утга хэлбэрээр, найруулгын тэгш хэмийг чанд баримтлан давтсан байдаг. Толгой сүүл холбохтой адил зөвхөн авиа, үг ижилсүүлэх төдийгүй **бүх л мөр бадгаар нь адилтган холбож, бас өгүүлсэн утга санаагаа улам лавируулан тодруулдаг онцлогтой юм. Олон бадаг эн зэрэгцсэн шүлэгт ойролцоо утгат үг, эсрэг утгат үг, зүйрлэл үг чухал үүрэгтэй байдаг**” (Чоймаа, 2017: 173) гэж тэмдэглэсэн байна. Энд гарч буй “... **бүх л мөр бадгаар нь адилтган холбож, бас өгүүлсэн утга санаагаа улам лавируулан тодруулдаг онцлогтой юм**” гэсэн өгүүлбэрийг бид анхаарах хэрэгтэй бөгөөд МНТ дахь шүлгийн эн зэрэгцүүлэх ёсоор жишээлэн харваас өгүүлэн буй шүлгийн эхний гурван мөрийн утга санааг дараагийн гурван мөр нь лавируулан тодотгосон нь илт байна.

ne'üle metü beye cinu

negüs odu'asu

netkel metü ulus cinu ken-e mede'ülkün tede

[**tulu** metü beye cinu

tulbas odu'asu

tuyal metü ulus cinu ken-e mede'ülkün tede]

(Нүүл (үүл) мэт бие чинь

Нэхэс одвоос

Нэтгэл мэт улс чинь хэнээ мэдүүлэхүн тэд

[Тул мэт бие чинь

Тулбас одвоос

Туйал мэт улс чинь хэнээ мэдүүлэхүүн тэд] (хөр. Э.Э)

Уснаа явагч загасны төрлийн амьтнаас биеэр хамгийн жижиг жараахай сочин хөдлөх үедээ жирс жирс мэт хөдлөх бол монгол орны гол мөрөнд бүхий хамгийн том загас болох тул тулбас тулбас хөдлөх бөгөөд энэхүү том, жижиг амьтдын сочин хөдлөх хөдөлгөөнийг *жирс*, *тулбас* гэх үгээр илэрхийлсэн нь үйл хөдлөлийг тухайн амьтдын онцлогт тааруулан машинд зөв оноон нэрлэдэг монголчуудын гярхай ажиглалт, монгол хэлний дүрслэх ур чадварын илрэл юм. Тулбас хийдэг усны амьтдын дотроос хамгийн нь том нь тул бол нэхэс хийдэг зүйлийн дотроос хамгийн том нь магадгүй “нүүл (их үүл)” юм. Нэхэс, тулбас гэх энэ хоёр үг нь ямагт хөдлөнгө зүйлд хэрэглэгдэж байгааг бид анхаарах хэрэгтэй. Гэхдээ байн байн хөдөлдөг бус байж байгаад л ямар нэгэн шалтгааны улмаас хөдлөх тэр зүйлийг хэлж байна. Тул загас бол энгийн загас жараахай шиг тэр бүр түргэн түргэн огцом хөдөлдөг амьтан биш алгуур аажим хөдөлнө. Үүн лүгээ тэрхүү нүүл (нүүгэлтсэн их үүл) ч хүчтэй салхи үүдэхгүй бол тэр бүрийд нүүж, арилж алга болох нь үгүй. Басхүү “*нүүл*”-ээр тэнгэр, тул-аар газрыг төлөөлүүлэн, тэнгэр-хүн-газар гэсэн босоо чиглэлийн дагуу зүйрлэсэн зүйрлэл ч байж болох юм.

6. Монгол, манж хэлний баримтаар холбох нь: 'нүүх-, нэхэс' хэмээх үгийн тухайд

Манж хэлэнд 'үүл'-ийг *tugi* (Шархүү, 1968: 352) гэнэ. Энэхүү *tugi* нь монгол хэлний түгэ- (*tuge-*) гэсэн үйл үгтэй язгуур нэг юм. Man. *tugi* ~ Mon. *tuge*. Манж хэлний *tu-* хэмээх язгуураас доорх төрөл үгс үүсжээ.

Man. <i>tule</i>	<i>tu-le</i>	(Mon. <i>γadan-a</i>)	(MGBB: 9-55a)
Man. <i>tulergi</i>	<i>tu-le-ergi</i>	(Mon. <i>γadayadu</i>)	(MGBB: 9-55a)
Man. <i>tuku</i>	<i>tu-ku</i>	(Mon. <i>γadar</i>)	(MGBB: 15-53a)
Man. <i>tuwa</i>	<i>tu-wa</i>	(Mon. <i>γal</i>)	(MGBB: 14-78b)
Man. <i>tun</i>	<i>tu-n</i>	(Mon. <i>aral</i>)	(MGBB: 1-77b)
Man. <i>tuči-</i>	<i>tu-či</i>	(Mon. <i>γar-</i>)	(MGBB: 13-72b)
Man. <i>tuwa-</i>	<i>tu-wa</i>	(Mon. <i>üje-</i>)	(MGBB: 22-2a)

Дээрх жишээнээс харвал, манж хэлний 'tu-' хэмээх язгуур нь 'гарах' гэсэн утгыг илтгэж байна. Манж хүн 'үүл'-ийг гарсан юм, монгол хүн 'үүл'-ийг нүүдэг юм гэсэн утгаар анхлан ойлгож нэршүүлснийг эл нэршлээс харж болно. Чингэж үзвэл, манж, монгол хэлэнд хоёуланд нь үүл нь анхдагч утгаараа хөдөлгөөнт зүйлийг зааж байжээ. Хэлний хувьслын үүднээс 'negülen' хэрхэн 'egüle' болсныг үзүүлбэл:

negülen > *negüle* / *egüle* > *e'üle* > *üle*

'Нэхэс хийх' хэмээх дүрс дуурайх үгтэй ижил өгүүлэмжийг МНТ-оос хайж үзвэл МНТ §230: *uyilsun qor ubis kiküi-tür udal-ügei bayidaltan uriyarqun kebte'ül minu qutan qor qubis kiküi-tür qojit ese bayiqsat qurdun yabudaltan kebte'ül minu* (Rachewiltz, 1972: 133)

Уйсан (Үйсэн) хор
Увис хийхүйд
 Удалгүй байдалтан
 Уриархан хэвтүүл минь
 Худан хор
Хувис хийхүйд
 Хожид эс байгсад
 Хурдан явдалтан хэвтүүл минь (хөр. Э.Э)

Увис, хувис хэмээх үгийг үгийн бүтцээр задалбал *ubi-*, *qubi-* хэмээх үйл язгуурт тухайн үйлийн огцом хөдлөхийг заадаг '-s' дагавар залгаж үүссэн хэлбэр юм. Мөн энд гарч буй уйсан хор, худан хор нь хус, уд модны дурсаар хийсэн сум агуулах хөнгөн савыг хэлж байна. Хус, уд модны дурсаар хийсэн эл сум агуулах хөнгөн сав нь бие хөдлөх тэрхэн агшинд даган хөдлөх бөгөөд тэрхүү огцом хөдлөлийг увис, хувис хэмээх дүрслэх үгсээр илэрхийлжээ.

Энэ 'нэхэс' хэмээх үг монгол хэлэнд монгол хүний сэтгэхүйд хөдөлгөөнт, эргэж хөрвөдөг зөөлөн шинжтэй зүйлд хэрэглэгдэнэ. 'а' эгшгээр сэлгэж *нахис*

хийх, нахилзах гэх үг үүсгэнэ. Монгол хэлний тайлбар толиудад эдгээр дүрс дуурайх үгийг хэрхэн тайлбарласныг ажвал:

нахилзах - 1. уян нарийн юмны нахис нахис хөдлөх; модны мөчир нахилзан хөдлөх; 2. бөхөлзөх; нахилзах бөхөлзөх хорш. (Цэвэл, 1966: 372)

нахис хийх - хоромхон зуур нахийж хөдлөх (МХДТТ: 62059)

нахис нахис - түргэн түргэн нахилзаж хөдлөхийн байдал (Norjin, 1999: 715) гэх мэт.

Үргэлжилсэн үгийн зохиол, яруу найрагт ч эл дүрс дуурайх үгсийн утгын ялгаа, үгийн хүнд хөнгөнийг мэдэрч хэрэглэсэн жишээ арвин бий. Б.Явуухулан “Хар ус нуурын шагшуурга” шүлэгт:

Хар ус нуурын шагшуурга

Намрын салхинд исгэрнэ

Харахад нэг л гунигтай

Намс намс бөхөлзөнө (Явуухулан, 2000: 22)

гэх мэтээр Хар ус нуурын эргээр тохойрон ургасан тэрхүү хулс, зэгс намрын салхины аясаар найган бөхөлзөж буйг дүрслэхдээ намс намс гэх дүрс дуурайх үгийг давтан хэрэглэжээ. Хулс, зэгс нь хэлбэрийн хувьд туяхан нарийн бөгөөд түүний намрын салхинаа нахилзан хөдлөх хөдөлгөөнийг намс намс хэмээх дүрс дуурайх үгээр илэрхийлсэн нь шүлгийн аяз хийгээд хулс, зэгсний үйл хөдлөл, шинж чанартай тун чиг зохицсон юм. Энэ нь хэл сэтгэхүйн хамаарлын нэгэн содон жишээ бөгөөд дээрх жишээнээс үзвэл, нэхэс хэмээх үгийг хөнгөн, хөвсгөр, хөдлөнгө, хөдөлж байдаг зүйлд хэрэглэж буй нь илт байна.

7. Алтайн хэлнүүдийн баримт: Үгийн эхний “н” сугарах хийгээд сэлгэх үзэгдэл

Манж хэл:

Үгийн эхний “н” сугарсан	Үгийн эхний “н” сэлгэн хэлэгдэх
Man. nabdaha < abdaha ‘навч’	Man. nabdaha ~ abdaha ‘навч’
Man. nemu < emu ‘нэг’	Man. ni ~ i ‘тэр’
Man. ni < i ‘тэр’	Man. niman ~ iman ‘ямаа’
Man. niman < iman ‘ямаа’	Man. niqursun ~ iqu̇rsun ‘нугас’ (Мижиддорж, 1976: 157)

Монгол хэл:

Үгийн эхний “н” сугарсан	Үгийн эхний “н” сэлгэн хэлэгдэх
Mon. науаџи < аџаџи ‘агч’	Mon. nabtayar ~ abtayar ‘автгар’
Mon. nidуџан < idуџан < udуџан ‘удган’	Mon. nalaуи ~ alaуи ‘алуу’
Mon. nilbusun < yilbusun < ilbusun ‘илбус’	Mon. naki ~ aki ‘ахи-’
Mon. nidqa < idqa ‘ятга-’	Mon. nidkel ~ idkel ‘итхэл’ Mon. nidkere ~ idkere ‘итгэр-’

	Mon. niγta ~ igča ‘игч’
Mon. nika < ika ‘нэг’ (Могол хэлэнд)	Mon. nijigine ~ ijigine ‘ижгэнэ-’ Mon. nirjigine ~ irjigine ‘иржгэнэ-’
Mon. nungγasun < unγasun < unγasu ‘унгас’ Mon. nuqu < uqu ‘ух- (малтах)’	Mon. niγsirekü ~ igsirekü ‘игшир-’
Mon. nebtü < ebtü < ibt ‘ивт’ (Ойрад аялгуунд)	Mon. nisuyun ~ isuyun ‘исуун’
Mon. neliyed < eliyed ‘нэлээд’ (Ойрад аялгуунд)	Mon. ničara < ičara ‘яцар-’
Mon. nembüle < embüle ‘өмбөл’ (МНТ)	Mon. nömüri ~ ömüri ‘өмөр’
Mon. alurqai < nalurqai ‘алархай’ (МНТ)	Mon. nunjıγar ~ unjıγar ‘унжгар’
Mon. nende < ende ‘энд-’	Mon. nelüiyi ~ elüiyi ‘элий-’

Солонгос хэл:

Үгийн эхний “н” сугарсан
Kor. ntak < tak ‘ширээ’
Kor. ni (nit) < i ‘шүд’
Kor. ni (nir) < i ‘энэ’

Япон хэл:

Үгийн эхний “н” сугарсан
Jap. ninu < inu ‘нохой’
Jap. niru < iru ‘байх, орших’
Jap. nue < ue ‘дээр’

Мөн Монгол И Юй тольд: “nigen” хэмээх үгийг 亦下 igen гэж буулгасан нь дундад үеийн монгол хэлний зарим нутгийн аялгуунд үгийн эхний ‘n’ суларсан, эсвэл ‘n’-тэй, ‘n’-гүй сэлгэн хэлж байсны баримт юм.

Дээрх жишээнүүдээс бид монгол хэл төдийгүй алтайн хэлнүүдийн хүрээнд үгийн эхний ‘n’ сугарах, сэлгэх үзэгдэл байсныг бэлхнээ харж болох бөгөөд энэхүү зүй тогтлын дагуу negülen > negüle / egüle > e’üle > üle болжээ гэж үзэж байна. Мөн эгшгээр эхэлж буй дийлэнх үгс нь өвөг алтайн хэлэнд гийгүүлэгчээр эхэлж байсан (ГЭГ) гэх эрдэмтдийн онол (Рамстедт 1957, Владимирцов 1929, Порре 1965, Street 1974, Старостин 2003)-ыг уг үг давхар баталж байгаа билээ.

8. Дүгнэлт

МНТ судлаач олонх эрдэмтэд МНТ-ы §245, §254-р зүйлд тохиолдож буй ‘ne’üle’ хэмээх үгийг хажуугийн хятад хадмал орчуулгад дулдуйдаж “хөгшин дархи мод”, “аварга том мод” гэсэн утгаар тайлж тайлбарлаж иржээ. Бидний ажиглалтаар, МНТ-ы монгол бичгээрх уг эхийг баримталсан Лувсанданзаны

“Алтан товч”, мөн МНТ дахь шүлгийн тогтолцоо, тус зохиолд өгүүлсэн үүлний үнэлэмж, монгол болон алтайн хэлнүүдийн үгийн эхний ‘н’ сугарах, сэлгэх үзэгдэл, ‘ne’üle’ хэмээх үгтэй холбогдож буй ‘neküs’ (нэхэс) гэх үгийн утга зэргийг ажиглан ‘ne’üle’ нь *хөгшин, аварга том мод* бус харин *нүүл* (бөөн их үүл) буюу “үүл” гэсэн үгийн эхэндээ ‘н’-тэй хэлбэр гэж үзлээ.

Орчин цагийн монгол хэлний “үүл” хэмээх үг нь эртний монгол хэлэнд ‘negülen’ гэсэн хэлбэртэй байсан бөгөөд дундад үеийн монгол хэлний үед ‘ne’üle/e’üle’ гэсэн хоёр хувилбараар хэлэгдэх болжээ. Гэхдээ утгын хувьд ‘e’üle’ нь энгийн үүлийг, ‘ne’üle’ нь бөөн их үүлийг заан нэрлэж байсан болов уу гэж таамаглаж байна.

Ном зүй

- Lubsangdanzin.** (1990). *Altan tobči*. Erten-ü qad-un ündüsülegsen törü yosun-u jokiyal-i tobčilan quriyaγsan altan tobči kemekü orosibai: Гэрэл зургаар дахин хэвлэсэн эх. Эрхлэн хэвлүүлсэн Ш.Бира. Улаанбаатар, Улсын хэвлэлийн газар. [Lubsangdanzin. *The Golden summary which relates briefly the deeds of civil governing established by ancient emperors*. Photographically reproduced edition. Edited and published by Sh.Bira. Ulaanbaatar, State Publishing House. 1990]
- Їeēenbayatur.** (2005). Mongγol-un niyuča tobčiyān daki “oyilaju” gesen üge-yin qajayū-yin orčiyulū-a-yin endegürel. *Öbürmongγol-un neyigem-ün sinjilekü uqayan-u sedkül, №1*. [Tsetsenbaatar. On the mistake in the Interlinear translation of “oyilaju” in *The Secret History of the Mongols*. Journal of Social Sciences of Inner Mongolia, №1. 2005]
- Norjin.** (1999). Mongγol kelen-ü toli. Čiyululta qayalū-a qota-yin yerüngkei keblekü üyiledbüri. [Norjin. Dictionary of the Mongolian language. The General Printing Factory of Chuluunkhaalga city. 1999]
- Poppe, N.** (1965). *Introduction to Altaic linguistics*. Wiesbaden: Otto Harrassowitz.
- Ramstedt, G. J.** (1952). *Einführung in die altaische Sprachwissenschaft I*. Lautlehre, Bearbeitet und herausgegeben von Pentti Aalto [=MSFOu 104:1], Helsinki, 1957; *Einführung in die altaische Sprachwissenschaft II*. Formenlehre, Bearbeitet und herausgegeben von Pentti Aalto [=MSFOu 104:2], Helsinki, 1952.
- Sayinčoytu, B.** (2003). “Mongγol-un niyuča tobčiyān” daki jarim üge-yin qajayū-yin orčiyulū-a-yi kinaqu ni. *Mongγol sudulul sedkül, №3*. [Saintsoqt. In the ‘Mongγol-un niyuča tobčiyān’, the meanings of some words are explained, *Mongolian studies, №3*. 2003]
- Seēenčoytu.** (1989). *Mongγol üges-ün ijayur-un toli*. Kökeqota: Öbür Mongγol-un Arad-un keblel-ün qoriy-a. [Setsentsogt. *Dictionary of Mongolian Word Origins*. Hohhot: People's Publishing House of Inner Mongolia. 1989]
- Starostin, S.A., Dybo, A. V., Mudrak,** (2003). *O. A. Etymological Dictionary of the Altaic Languages*. Leiden: Brill.
- Street, J.** (1973). *On the lexicon of Proto-Altaic: A partial index to reconstructions*. Madison: Center for East Asian Studies, University of Wisconsin–Madison

- Владимирцов, Б.Я.** (1929). *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*. Введение и фонетика. Ленинград. [Comparative Grammar of the Written Mongolian Language and the Khalkha Dialect: Introduction and Phonetics. Leningrad, 1929]
- Гансүх, Ч.** (2019). Хэсэг байшингийн монгол бичээс буюу “Алтан цогт харшийн бичээс”-ийн тухай. *Нүүдэлчдийн өв судлал*. Том. XX-II. Fasc. 1-19. Улаанбаатар. [Gansukh, Ch. Kheseg baishingiin mongol bichees buyuu “Altan tsoigt kharshiin bichees”-iin tuhai. [On the Mongolian Inscription of a Keseg Bayising, or the “Inscription of the Altan Čoytu Qarsi”] Studies on the Heritage of Nomads. Tom. XX-II. Fasc.1-19. Ulaanbaatar, 2019]
- Лувсанжав, Ч., Шархүү, Г.** (1968). *Манж монгол толь*. Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн хэвлэх үйлдвэр. [Luvsanjav, Ch., Sharkhuu, G. Manj mongol toli [*Manchu-Mongolian Dictionary*] Ulaanbaatar, Academy of Sciences Publishing House. 1968]
- Мижиддорж, Г.** (1976). Монгол, манж хэлний ижил язгуурт үндсийн бүтээврийн өвөрмөц тохироо. *Хэл зохиол судлал*. XII. Улаанбаатар. [Mijiddorj, G. Mongol, manj khelnii ijil yazguurt ündsiin бүтээврийн өвөрмөц тохироо [The distinctive structural correspondences of cognate roots in Mongolian and Manchu]. Ulaanbaatar, 1976]
- Нацагдорж, Б.** (2020). Хэсэг байшингийн хөшөөний бичээс ба XVI-XVII зууны үеийн Монголын түүхэнд холбогдох хэдэн асуудал. *Acta Historica Mongolica*. Том. XXI. Fasc.8. Улаанбаатар. [Natsagdorj, B. Kheseg baishingiin khüshüünii bichees ba XVI-XVII zuunii үеийн Монголын түүхэнд холбогдох хэдэн асуудал [The Inscription of a Section of the Palace Monument and Several Issues Related to the History of Mongolia in the 16th-17th centuries]. *Acta Historica Mongolica*. Tom. XXI. Fasc. 8. Ulaanbaatar, 2020]
- Хуучин манж данс.** (2021). Боть VII. Манж хэлнээс орчуулсан Э.Эрдэнэзуу, “Соёмбо принтинг” хэвлэлийн газар. [Ejehe dangse. Vol VII. Translated from Manchu by E. Erdenezuu. Soyombo printing, 2021]
- Цэвэл, Я.** (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар. [Tsevel, Ya. *Mongol khelnii товч тайлбар толь* [Concise Explanatory dictionary of the Mongolian language]. Ulaanbaatar, 1966]
- Явуухулан, Б.** (2000). *Мөнгөн хазаарын чимээ*. Улаанбаатар. [Yavuukhulan, B. *Möngön khazaariin chimee*. [The jingle of silver reins]. Ulaanbaatar, 2000]

Монгол хэлээрх Монголын нууц товчоон

- Čengdū.** (2017). *Цэнд гүнгийн хөрвүүлсэн Монголын нууц товчоо*. Улаанбаатар, Ти Ди Ар Пи. [Tsend güngiin khörvүүлсэн Mongoliin nuuts товчоо [The Secret History of the Mongols, translated by Duke Tsend] Ulaanbaatar, Ti Di Ar Pi, 2017]
- Damdinsürüng, Čengdū.** (1947). *Mongyol-un niyuča tobčiyan*. Улаанбаатар, Ulus-un keblekü üyiledbüri. [Damdinsuren, Ts. *The Secret history of the Mongols*: State Publishing House. 1947]

- Дамдинсүрэн, Ц.** (1957). *Монголын нууц товчоо*. Хоёр дахь удаагийн хэвлэл. Улаанбаатар, Улсын хэвлэлийн газар. [Damdinsuren, Ts. *The Secret History of the Mongols*. Second edition. Ulaanbaatar, State Publishing House. 1957]
- Дамдинсүрэн, Ц.** (1976). *Монголын нууц товчоо*. Гурав дахь хэвлэл. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Damdinsuren, Ts. *The Secret history of the Mongols*. Third edition. Ulaanbaatar, State Publishing House. 1976]
- Дамдинсүрэн, Ц.** (1990). *Монголын нууц товчоо*. Дөрөв дахь удаагийн хэвлэл. Улаанбаатар, Улсын хэвлэлийн газар. [Damdinsuren, Ts. *The Secret history of the Mongols*. Fourth edition. Ulaanbaatar, State Publishing House. 1990]
- Гадамба, Šangjimitub.** (1990). *Mongγol-un niγuča tobčiyān* (Qudam (ijayur erten-ü) mongγol bičig-iyer mongγol bičig, udq-a sudulul-un egüden-eče Šangjimitub-un Gadamba-yin töсүgelen niγtalaju sergügegsen seyiregölge eke, tayilburi). Ub: Ulus-un keblel-ün γajar. [Gadamba, Sh. *The Secret history of the Mongols*. Ulaanbaatar, State Publishing House. 1990]
- Čeringsodnam, Dalangtai.** (1993). *Mongγol-un niγuča tobčiyān-u orčiyuly-a tayilburi*. Begejing, Ündüsüten-ü keblel-ün qoriy-a. [Tserensodnom, Dalangtai. *Translation and Commentary of the Secret History of the Mongols*. Beijing: National Publishing House. 1993]
- Цэрэнсодном, Д.** (2000). *Монголын нууц товчоо* (эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар). Улаанбаатар, Мөнхийн үсэг. [Tserensodnom, D. *The Secret history of the Mongols* (Scientific translation and commentary). Ulaanbaatar: Munkhiin useg printing. 2000]
- Сумьяабаатар, Б.** (1990). *Монголын нууц товчоо*: Үсгийн галиг. Улаанбаатар, Д.Сүхбаатарын нэрэмжит Улсын хэвлэлийн комбинат. [Sumiyabaatar, B. *The Secret history of the Mongols: Transliteration*. Ulaanbaatar: D.Sukhbaatar State Publishing House. 1990]
- Сумьяабаатар, Б.** (2020). *Монголын нууц товчоон: иж судалгаа*. Улаанбаатар, “Жиком пресс” хэвлэлийн газар. [Sumiyabaatar, B. *The Secret History of the Mongols: A Comprehensive Study*. Ulaanbaatar, “Gcom press” printing. 2020]
- Чоймаа, Ш.** (2002). “Монголын нууц товчоон”, Лувсанданзаны “Алтан товч” эхийн харьцуулсан судалгаа. Улаанбаатар, МУИС-ийн хэвлэлийн газар. [Choimaа, Sh. *A Comparative Study of Manuscripts: The Secret History of the Mongols and Luvsandanzan's Altan Tovch*. Ulaanbaatar, NUM publishing, 2002]
- Чоймаа, Ш.** (2006, 2015). *Монголын нууц товчоон*. “Монголын түүхэн сурвалж бичиг”-ийн 30 ботийн I боть. Улаанбаатар, Соёмбо принтинг. [Choimaа, Sh. *The Secret history of the Mongols*. Historical Sources of Mongolia, Volume I of 30 Volumes. Ulaanbaatar: Soyombo printing, 2006, 2015]
- Чоймаа, Ш.** (2011). *Монголын нууц товчоо эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг*. Улаанбаатар, Мөнхийн үсэг. [Choimaа, Sh. *The Secret History of the Mongols: A New Translation with Common Explanations of Ancient Words and Phrase*. Ulaanbaatar, Munkhiin useg printing. 2011]

- Чоймаа, Ш.** (2019, 2022). *Монголын нууц товчоон*. Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг. Гурав дахь, дөрөв дэх хэвлэл. Улаанбаатар: “Болор судар” хэвлэлийн газар. [Choimaa, Sh. *The Secret History of the Mongols: A New Translation with Common Explanations of Ancient Words and Phrase*. Third and fourth edition. Ulaanbaatar, Bolor Sudar printing. 2019, 2022]
- Гантогтох, Г.** (2018). *Монголой нюуса тобшоон* (буриад монгол аялгуу). Улаанбаатар, “Соёмбо принтинг” хэвлэлийн газар. [Gantogtokh, G. *The Secret history of the Mongols*. (Buryat Mongolian dialect). Ulaanbaatar, Soyombo printing. 2018]
- Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоо.* (2024). Улаанбаатар, Сэлэнгэ пресс. [*The Secret History of the Mongols with Detailed Commentary*. Ulaanbaatar, Selengge press. 2024]

Монгол бичгээрх Монголын нууц товчоон

- Bayar.** (1981, 1998). *Mongγol-un niyuča tobčiyān*. Angqan-u keblel. 3 boti. Qoyaduyar keblel 2 boti. Köke qota, Öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a. [Bayar. *The Secret history of the Mongols*. Hohhot, Inner Mongolia People's Publishing House. 1981, 1998]
- Eldengdei, Čengdü., Ardajab, Eldengdei.** (1986). *Mongγol-un niyuča tobčiyān*: seyiregülül tayilburi. Köke qota, Öbür mongγol-un suryan-un kümüjil-ün keblel-ün qoriy-a. [Eldengdei, Ts., Ardajab, E. *The Secret history of the Mongols: Restoration, commentary*. Hohhot, Inner Mongolia Education Press Committee. 1986]
- Eldengdei, Oyundalai, Asaraltu** (1991). *Mongγol-un niyuča tobčiyān-u jarim üges-iin tayilburi*. Köke qota, ündüsüten-ü keblel-ün qoriy-a. [Eldengdei, Oyundalai, Asaraltu. *Explanation of Some Words in The Secret History of the Mongols*. Hohhot, National Publishing Committee. 1991]
- Irinčin, Yekemingyadai.** (1987). *Mongγol-un niyuča tobčiyān sergügelte*. Köke qota, Öbür mongγol-un yeke surγayuli-yin keblel-ün qoriy-a. [Irinčin, Ye. *Restoration of the Secret history of the Mongols*. Hohhot, Press Committee of the University of Inner Mongolia, 1987]
- Kesigbatu, Bayar.** (1941). *Yuwan ulus-un niyuča tobčiy-a*. Čiyululta qayaly-a: Terigün noyan-u ordun-u darumal-un yajar. [Kesigbatu, B. *The Secret History of the Yuan dynasty*. Čiyululta qayaly-a: The printing office of the Supreme lord's palace. 1941]
- Quvasai Duyarjab.** (1984). *Mongγol-un niyuča tobčiyān-u qaryuyulun kinaγsan debter*. Qayilar, Öbür mongγol-un soyol-un keblel-ün qoriy-a. [Quvasai Duyarjab. *The Secret History of the Mongols: Revised and Edited Volume*. Hailar, Inner Mongolia Cultural Publishing House. 1984]
- Tayičiyud Mansang.** (2021). *Sineken körbegüljü sinedken tayilburilaysan “Mongγol-un niyuča tobčiyān”*. Shenyang, Liyoning-un ündüsüten-ü keblel-ün qoriy-a. [Tayičiyud Mansang. *“The Secret History of Mongolia”, newly*

translated and reinterpreted. Shenyang, Liaoning Nationality Press Committee. 2021]

Бусад хэлээрх Монголын нууц товчоон

- Haenisch Erich.** (1941). *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, Harrasowitz. [Erich Haenisch. *The Secret History of the Mongols*. Leipzig, Harrasowitz. 1941]
- Igor de Rachewiltz.** (1972). Index to The Secret History of the Mongols. Bloomington: Indiana university.
- Igor de Rachewiltz.** (2004). *The Secret History of the Mongols*. A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century, Translated with a historical and philological commentary. Volume I, II. Leiden-Boston: Brill.
- Козин Сергей Андреевич.** (1941). *Сокровенное сказание: Юань чао би ши*. Монгольский обыденный изборник, Том I. Ленинград: Издательство Академии Наук СССР. [Kozin Sergey Andreevich. *The Secret History: Yuan Chao Bi Shi*. Mongolian Everyday Anthology, Volume I. Leningrad, Publishing House of the Academy of Sciences of the USSR. 1941]
- Urgunge Onon.** (2005). *The Secret History of the Mongols: The Life and Times of Chinggis Khaan*. London and New York: Routledge Curzon.
- 小澤重男. (1989). 元朝秘史全釈続改, 下, 東京: 風間書房. [Ozawa Shigeo. *Complete Commentary on the Secret History of the Mongols. Revised Continuation*. Volume 3. Tokyo: Kazama Shobo. 1989]
- 栗林均. (2009). 元朝秘史モンゴル語漢字音訳・傍訳漢語対照語彙, 仙台: 東北アジア研究センター. [Kuribayashi Hitoshi. *The Secret History of the Yuan Dynasty: Mongolian-Chinese Phonetic Transcription and Parallel Translation Glossary*. Sendai: Northeast Asia Research Center. 2009]
- 栗林均. (2012). 元朝秘史傍訳漢語索引, 仙台: 東北アジア研究センター. [Kuribayashi Hitoshi. *The Secret History of the Yuan Dynasty: Indexed Parallel Translation in Chinese*. Sendai: Northeast Asia Research Center. 2012]

Товчилсон үг

MHT - Монголын нууц товчоон

MGBV - manju gisun-i buleku bidhe (Манж үгийн толь бичиг)

EJ - ejehe dangse (Хуучин манж данс)

EMQÜYSTO - erten-ü mongγol qaγad-un ündüsün-ü yeke sir-a tuyuji orosibai

QÜET - qaγad-un ündüsün-ü erdeni-yin tobči

YMUÜATTO - yeke mongγol ulus-un ündüsün altan tobči tuyuji orosibai

МХДТТ - Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь

ДТМНТ - Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоон



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>